



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны ээлжит бус 05 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 05 дугаар хуралдаан 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр болов.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 05 дүгээр хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ-ийн хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар ашиглах хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) тухай асуудлыг хэлэлцэж, тус хорооны хуралдааны 4 тогтоолыг батлан шийдвэрлэсэн.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 05 дугаар хуралдаанаар тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт) холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 4 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 5 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 138 тоот тогтоолоор 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг үндэслэн 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 139 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулсан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт болон Юнител ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 140 тоот тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 141 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн харилцаа холбооны сүлжээний 1 дугаар ашиглалтын хугацааг сунгаж тус тус шийдвэрлэв.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2023-11-16